

**Петро Матад Лимитэд (“Петро Матад” эсвэл “Компани” гэх)**

**XX талбайн Хайгуулын Өрөмдлөгийн талаархи Шинэчилсэн Мэдээлэл**

Петро Матад (AIM:MATD) нь Монгол Улсын зүүн хэсэгт байрлах XX талбайн Давсан Толгойн цооногийн өрөмдлөгийн үйл ажиллагааны талаар шинэчилсэн мэдээллийг хүргэж байна.

ДТ-3 цооногийн өрөмдлөгийг 2010 оны 10 дугаар сарын 27-ы өдөр 1,266 метрийн гүнд ул чулуунд хүргэж дуусгалаа.

Манай үндсэн зорилт болох Доод Цагаанцав болон түүний дээд талд байрлах Дээд Зүүнбаянгийн формацийн хэсгийг өрөмдөх үед нилээд хэмжээний нүүрсустөрөгчийн илрэл тогтоогдсон.

Каротажийн судлагааны урьдчилсан шинжилгээгээр энэхүү бүсд 5.5 метрийн зузаантай боломжийн цэвэр нефтлэг үе байгааг харуулж байна. Энэхүү нефтлэг үеийн сийрэгжилт нь дунджаар 23 хувь байна.

Доод Цагаанцавын формацийн элсэн чулуу бүхий 1,005-1,015 метрт 10 метрийн зузаантай сулавтар тосны илэрц тогтоогдсон бөгөөд 945-1216 метрт пентан хий өндөр үзүүлэлттэй байна. Петрофизикийн урьдчилсан шинжилгээгээр Доод Цагаанцавын формацийн элсэн чулуутай 935-аас 1,216 метр хүртэлхи нийт 281 метрийн зүсэлтэнд 20-иос дээш хувийн сийрэгжилт бүхий 50 гаруй метрийн зузаантай сайн чанарын агуулагч чулуулаг жигд тархсан байгааг тогтоосон. Гэсэн хэдий ч Доод Цагаанцавын зүсэлтэнд тогтоогдсон нүүрсустөрөгчийн ханалт бага байгаа нь энэхүү хэсэгт Цагаанцавын формацийг судлах нь тохиромжгүй болохыг харуулж байна.

ДТ-3 цооногоос зүүн хойд зүгт 8 километрийн зайд орших ДТ-1 болон ДТ-2 цооногуудын хооронд Цагаанцавын агуулагч давхарга үргэлжилж буй эсэхийг шалгах зорилгоор ДТ-3 цооногийн өрөмдлөгийг гүйцэтгэсэн. ДТ-1 болон ДТ-2 цооногийн нүүрсустөрөгчийн ханалтын үзүүлэлтийг ДТ-3 цооногийн ханалтын үзүүлэлттэй харьцуулбал ДТ-3-ын шингэний хураагуур нь ДТ-1 болон ДТ-2 цооногуудаас тусдаа болохыг харуулж байна. Тиймээс 3 хэмжээст сейсмийн (чичирхийллийн) судлагааны зураглалыг дахин боловсруулж хураагуур тус бүрийн хэмжээг тогтооно.

Мөн ДТ-3 цооногийн өрөмдлөгөөр Давсан Толгойн талбайн Цагаанцавын агуулагч давхаргын чанарыг тогтоох дээжийг илүү өргөн цар хүрээг хамарч авсан. ДТ-3 цооногийн өрөмдлөгөөр тогтоосон 50 метр буюу түүнээс илүү зузаантай агуулагч чулуулаг нь тус талбайн хувьд 2009 онд нийт олборлох боломжтой гэж тооцсон 121.5 сая баррел газрын тосны нөөцийг бодоход ашигласан 10.35 метрийн зузаалаг бүхий ашигт нефтийн давхаргаас илүү байна.

ДТ-3 нь Давсан Толгойн гүдэн бүтцийн (антиклинал) оройн хэсгийн дагуу өрөмдөх 2010 оны өрөмдлөгийн хөтөлбөрийн гуравдахь бөгөөд сүүлийн цооног юм. Тус цооногт бэхэлгээний янданг суулгаж, цементээр бэхжүүлсэний дараа

Ансай Юэнхуа компанитай байгуулсан өрмийн ажил гүйцэтгэх гэрээ дуусгавар болно.

Дээрхи гурван цооногоор тогтоосон агуулагч давхарга болон гүний хэмжилтийн мэдээллүүдийг нэгтгэн нийт Давсан Толгойн талбайн нөөцийн тооцоог ирэх өвлийн хугацаанд хянаж, 2011 оны эхээр гэрээт зөвлөх компаниар уг үнэлгээг дахин хийлгүүлэх юм.

2010 оны хөтөлбөрийн хүрээнд цооногийн тосны гарцийн туршилт хийгдэх байсан хэдий ч өрөмдлөгийн ажил хожуу эхэлж, зарим үед ажлын явц удааширч, цаг агаар хүйтэрснээр уг ажлыг энэ жилдээ хийхэд хүндрэлтэй боллоо. Мөн манай ажилд тохирох туршилтын туслах үйлчилгээний цамхаг байхгүй гэх мэт бусад шалтгаануудын улмаас манай компанийн туршилтын зөвлөх инженер уг ажлыг 2011 оны хавар хүртэл хойшлуулахыг санал болгосоныг Компани хүлээн зөвшөөрсөн.

Компани одоо өрөмдлөгийн ажлыг энэ жилдээ багтаан үргэлжлүүлэхээр өвлийн улиралд ажиллах боломжтой өрмийн цамхагийг түрээслэхээр ажиллаж байна. Тус өрмийн баг нь манай орныхтой ижил төстэй газарзүйн болон цаг агаарын нөхцөлд 12 дугаар сарын дунд хүртэл өрөмдлөг хийж байсан туршлагатай. Тус өрмийн цамхагийг гэрээлэх талаар хэлэлцээр эцсийн шатандаа явж байна. Гэрээг байгуулсан тохиолдолд 11 дүгээр сарын дундаас өрөмдлөгөө эхлүүлнэ.

Хэдийгээр цаг хугацааны боломжоос хамаарч гэрээнд зөвхөн нэг цооног өрөмдөхөөр төлөвлөж байгаа хэдий ч өрөмдлөг богино хугацаанд дууссан тохиолдолд хоёр дахь цооногийг өрөмдүүлэх саналыг мөн тусгасан. Компанийн техникийн багийнхан Давсан Толгойн талбайд тусдаа гүдэн бүтцийг (антиклинал) сонгож, цооногийн загвар гаргалаа. Өрөм түрээслэх гэрээ хийгдэж, ажлыг эхлүүлсэн тохиолдолд цооногийн байрлал, төлөвлөсөн гүний талаархи мэдээллийг хүргэх болно.

Петро Матадын Ерөнхий Гүйцэтгэх Захирал - Даглас Жэй МакГэй:

“ДТ-3 цооногийн өрөмдлөгөөр Цагаанцавын формацид нүүрсустөрөгчийн нааштай үр дүн гараагүй хэдий ч Зүүнбаянгийн формацид боломжийн хэмжээний нүүрсустөрөгчтэй давхаргыг илрүүлсэн нь чухал юм. Хийн өндөр үзүүлэлт, Цагаанцавын агуулагч давхаргын чанар зэрэг нь шинжлэх ухааны үүднээс ач холбогдолтой бөгөөд газрын тос болон байгалийн хий Давсан Толгой руу холоос нүүдэллэн шилжиж буйг харуулж байна.”

“Бид өрөмдлөгийн анхны жилдээ өрөмдсөн гурван цооногоос нүүрсустөрөгч илрүүлсэндээ баяртай байна. Бид Давсан Толгойн хайгуулын хөтөлбөрийн өрөмдлөгийн эхний үе шатыг амжилттай дуусгаж, дараагийн буюу дээрхи өрөмдлөгөөс олж авсан мэдээллээ нэгтгэж, үнэлгээ хийх үе шатандаа орлоо. Хөтөлбөрийн энэхүү үе шатанд бид Давсан Толгойд хийгдсэн сейсмо-хайгуулын (чичирхийлийн) 3 хэмжээст судлагааны мэдээллийг дахин боловсруулж, зураглалыг шинээр хийж, нөөцийн хэмжээг шинэчлэн тогтоох болно. Дээрхи судлагаануудын үр дүн нь бидний 2011 онд Давсан Толгойд гүйцэтгэх үнэлгээний өрөмдлөгийн ажлыг төлөвлөх үндэслэлийг бүрдүүлж өгөх юм.”

“Дээрхи ажлуудыг гүйцэтгэснээр 2010 оны өрөмдлөгийн хөтөлбөр бидний анх төлөвлөсний дагуу эцсийн шатандаа орно. Хөтөлбөрийн дагуу цооногийн туршилтанд тохирох туслах үйлчилгээний өрмийг олох боломжгүй байгаа нь хүндрэл учруулж байгаа ч манай техникийн баг болон гэрээт зөвлөх компанийн ажилтнууд үнэлгээний ажлаа хийсээр байна.”

“Мөн хайгуулын бусад хөтөлбөрүүд ч хийгдэж байна. Бидний хувьд хамгийн чухалд тооцогдож буй ажил нь энэ жилдээ багтааж Давсан Толгойд хийх нэмэлт өрөмдлөг юм. Түүнчлэн энэ өвлийн саруудад ХХ талбайд сейсмо-хайгуулын 2 болон 3 хэмжээст судлагаа хийхээр төлөвлөж байгаа бөгөөд одоогоор уг ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийн материалуудыг хүлээн аваад шалгаж байна.

Монгол орны баруун болон баруун урд хэсэгт орших Богд- IV ба Онги- V хайгуулын талбайнуудад 4000 цэгийг хамарсан хүндийн хүчний гүйцээх судлагааг хийж дуусгасан бөгөөд уг судлагааны мэдээллийг мөн урьд нь хийсэн сейсмийн 2 хэмжээст судлагааны мэдээлэлтэй нэгтгэж боловсруулна.”

Энэхүү шинэчилсэн мэдээлэлд агуулагдсан техникийн мэдээллийг Компанийн Хайгуулын Менежер Доктор Жеймс Күүгэн хянаж, зассан болно. Доктор Күүгэн нь Хойд Америк болон олон улсын газрын тосны хайгуул, ашиглалтын салбарт 29 жил ажилласан туршлагатай Газрын тосны геологич юм. Тэрээр Америкийн Газрын Тосны Геологичдын Холбоо болон Америкийн Геологийн Нийгэмлэгийн гишүүн юм.

Мэдээллийг хянан тохиолдуулагч нарын анхааралд:

Петро Матад Лимитед компанийн тухай

Петро Матад нь Монгол Улсад газрын тосны хайгуул хийх, цаашид ашиглалт, үйлдвэрлэл явуулах зорилго бүхий группын толгой компани юм. Тус групп нь Монгол Улсын Засгийн газартай Бүтээгдэхүүн Хуваах тухай гурван гэрээг дангаар байгуулан ажиллаж байна. Группын үндсэн хөрөнгө нь Монгол Улсын зүүн хэсэгт орших 14,250 хавтгай дөрвөлжин километр талбай бүхий газрын тосны ХХ талбайн Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ (“БХГ” гэх) юм. Үлдсэн хоёр талбай болох IV ба V талбайд нь Монгол Улсын төв хэсэгт оршдог бөгөөд хоёр талбай нийтдээ 71,040 хавтгай дөрвөлжин километр талбайг хамарна.

Петро Матад Лимитед нь 1483V компанийн бүртгэлийн дугаартайгаар Айл эф Мэн (Isle of Man) аралд үүсэн байгуулагдсан. Албан ёсны бүртгэлтэй төв байр нь Виктори Хаус, Проспет Хилл, Дуглас, Айл эф Мэн, Ай Эм 1, 1IKью (Victory House, Prospect Hill, Douglas, Isle of Man, IM1 1EQ)-д байрладаг.

**Нэмэлт мэдээллийг:**

Петро Матад Лимитэд  
Ерөнхий Гүйцэтгэх Захирал - Даглас Жэй МакГэй (Douglas J. McGay)  
+976 11 331099

Уэстхауз Секьюритиз Лимитэд  
Ричард Бэти/Питр Нортон  
+44 (0)20 7601 6100